



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/42

Ховд

Боловсрол, соёл, урлагийн газрын  
бүтэц орон тоог батлах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын бүтэц орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хавсралтаар баталсан бүтэц орон тоог цалингийн санд багтаан байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /М.Пүрэвхүү/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/515 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН  
ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл
1	Дарга	1	ТЗ-10
2	Сургалт, судалгаа арга зүйн хэлтсийн дарга /насан туршийн боловсрол/	1	ТЗ-7
3	СӨБ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
4	Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
5	Монгол хэл уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
6	Математик, мэдээлэл зүйн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
7	Гадаад хэлний боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
8	Хими биологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
9	Физикийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
10	Газарзүйн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
11	Дуу хөгжим, биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
12	Дизайн технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
13	Түүх, Нийгмийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
14	Соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
15	Дотуур байр хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
16	Статистик, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-6
17	Төсөв хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
18	Ахлах нягтлан бодогч	1	ТҮ-8
19	Архив, бичиг хэрэг	1	ТҮ-5
20	Нярав	1	ТҮ-4
21	Үйлчлэгч	1	ТҮ-1
22	Жолооч	1	ТҮ-3
	Нийт	22	